

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 06/268

НШУС

2006

МЭДЭЭЛЛИЙН НИЙГЭМ БА ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ

М.Зулькафиль*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор (Sc.D.), МУИС-ийн тэргүүлэх профессор

Түлхүүр үг: Мэдээллийн нийгэм, мэдээллийн глобаль сүлжээ, "мэдээллийн соёл иргэншил, мэдээллийн хувьсгал.

Сүүлийн жилүүдэд бидний үгийн санд хамгийн идэвхтэй нэвтэрч буй үгсийн тоонд мэдээллийн эрин, мэдээллийн технологи, мэдээлэл зүй, мэдээллийн нийгэм, цахим мэдээлэл зэрэг үг багтах болсон нь манай орны хөгжлийн өнөөгийн хандлага, дэлхий даяар эрчимтэй явагдаж байгаа даяарчлалын үйл явцтай холбоотой юм.

"Хүйтэн дайн" дуусч, үзэл суртлын хоёр системийн хоорондох зөрчил, арилж, дэлхий ертөнцийг хоёр өөр өнгөөр харж үнэлэлт дүгнэлт өгдөг үе түүх болон үлдсэнээс хойш хориод жилийг ардаа орхилоо. Улс орнуудын хооронд аажим аажмаар шинэ харилцаа төлөвшиж эхэлсэн. Ийм үйл явц чөлөөт ардчилсан нийгмийн хөгжлийн нэг гол хүчин зүйл болсон сэтгүүл зүйд хүчтэй

нөлөөлж байна. "Хүйтэй дайны" үзэл баримтлал болон олон улсын үйл явдлыг улиг болсон хоёр өөр өнгө, арга барилаар тайлбарлахаас татгалзах болсон нь ОНМХ-ийн үйл ажиллагаанд гарсан чанарын шинэ үзэгдэл бөгөөд энэ нь орчин үеийн дэлхий дахинд хүчтэй ажиглагдаж буй мэдээлэл харилцааны шинэ хувьсгал, бодит үйл явцын нөлөөллийн илрэл юм.

Өнөөдөр олон орны ОНМХ-ийн үйл ажиллагаанд хэдийгээр үндэсний, бүс нутгийн онцлог, өөрийн гэсэн загвар, школ хадгалагдаж, уламжлалт арга барилаар хөгжиж байгаа боловч маш олон нийтлэг зүйл ажиглагдаж байна. Ялгаатай шинжээс нийтлэг зүйл нь илүү их гэж хэлж болно. Энэ бол юуны өмнө дэлхий дахиныг хоёр өөр нүдээр харах, зөрчилт сөргөлдөөнт хандлагаас татгалзаж, теле коммуникаци, эдийн засгийн болон соёлын шинэ боломж, өөрчлөлтийг өөртөө агуулж буй мэдээлэл харилцааны даяарчлалын үйл явцад аль

ч орон идэвхтэй хамрагдаж байгаатай холбоотой юм. Орчин үеийн мэдээлэл харилцааны системийн гол шинж болох Интернет, ОНМХ-үүдийн даяарчлал, мэдээллийн тоон технологид (дигиталчлагдах) шилжих, хоорондоо нэгдэн нийлэх үйл явц нь дэлхий дахины сэтгүүл зүйн нийтлэг шинж болж байна.

Олон улсын харилцаанд гарсан ийм ахиц өөрчлөлтүүд мэдээлэл харилцааны технологийн хувьсгалын эрчимтэй хөгжилтэй давхцаж, энэ нь ОНМ-ийн бүх хэрэгслүүдийн үйл ажиллагаа, нөхцөл байдлыг үндсээр нь өөрчлөхөд нөлөөлсөн. Дэлхийн тавцанд мэдээлэл харилцааны глобаль систем болох Интернет хүчтэй нэвтэрч, дэлхий дахины нэгдмэл виртуаль орон зайг бий болгосноор мэдээллийн нийгмийн тухай үзэл баримтлалыг бодит зүйл болгох урьдчилсан нөхцөл бүрдсэн юм. Өнөөдөр мэдээллийн нийгэм буюу Information society хэмээх нэр томъёог аж үйлдвэржсэний дараах нийгмийн хамгийн сүүлчийн төрөл, аж үйлдвэржсэн нийгмийн хөгжлийн хамгийн сүүлчийн үе шат, нийгэм-эдийн засгийн формацийн өвөрмөц төрөл, "мэдээллийн соёл иргэншил" болох хүн төрөлхтний хөгжлийн шинэ үе¹ гэсэн хэд хэдэн утгаар хэрэглэж байна.

Мэдээллийн нийгмийн тухай нийгэм-улс төрийн үзэл баримтлал хэд хэдэн хөгжингүй орнуудад 70-аад оны эцэс, 80-аад оны эхэнд бараг нэгэн зэрэг үүсчээ. Энэ чиглэлийн хамгийн нэртэй төлөөлөгчид

бол А.Турен, П.Серван-Шрайбер, М.Понятовский (Франц), М.Хоркхмайер, Ю.Хабермас, Н.Луман (Герман), М.Маклюэн, Д.Белл, З.Бжезинский, О.Тофлер (АНУ), Д.Масуда (Япон) юм.

Мэдээллийн нийгмийн тухай бүх үзэл баримтлалд тодорхой хэмжээний ялгаа байгаа боловч энэ нийгмийн хамгийн гол онцлог шинж, бүрэлдэн төлөвших нөхцөл нь үндэсний, бүс нутгийн, глобаль хүрээнд үйлчилдэг өндөр технологийн мэдээллийн сүлжээ мөн гэдгийг бүгд хүлээн зөвшөөрсөн байдаг. Мэдээллийн нийгмийн эдийн засгийн гол салбар нь мэдээллийн үйлдвэрлэл байдаг бөгөөд мэдээлэл таваарын үндсэн төрөл, нийгмийн үнэт зүйлийн нэг болдог онцлогтой юм. Энэ бүтээгдэхүүний ач холбогдол, үнэ цэнэ нь бараа таваарын "уламжлалт" төрлүүдтэй харьцуулахад эрс өвөрмөц, ер бусын шинжтэй байдаг. Судлаачдын үзсэнээр эдийн засгийн энэ салбар ирээдүйд аливаа орны тэргүүлэх чиглэл болж, хөгжлийн хамгийн гол хүчин зүйл болдог байна. Мэдээллийн нийгэмд мэдээллийг зохион байгуулах, үйлдвэрлэх, түгээхэд хэвлэл, радио, телевиз болон ОНМХ-ийн бусад төрөл, хэлбэрийг, мөн цэрэг-аж үйлдвэрийн иж бүрэн нэгтгэлийг хамарсан хил дамнасан компаниуд гол байр суурийг эзэлдэг. Мэдээллийн нийгэмд үндэсний уламжлал, ёс заншил соёл ихээхэн өөрчлөгдөж шинэ агуулгаар баяжин хөгждөг байна. Үүнийг Оросын эрдэмтэн А.А.Зиновьев "баруунчлагдах үйл явц"² гэж

нэрлэсэн бол судлаач Ю.Хабермас "дотоод ертөнцийн колоничлол"³ гэж тодорхойлсон байдаг. Мэдээллийн нийгмийн талаарх энэхүү үзэл баримтлалыг технократ үл гүйцэлдэх үзэл, компьютер топи буюу компьютерийн үл биелэгдэх мөрөөдөл гэж үзээд шүүмжлэлтэй хандах явдал түгээмэл ажиглагдах болов. Компьютопи бол орчин үед шинжлэх ухаан-техникийн хөгжилтэй холбоотой гарч ирсэн нийгмийн бодит үйл явцад хандах "аж үйлдвэржсэн нийгмийн дараах" ухамсрын нэг илрэл юм.

Мэдээллийн нийгэм үүсэн төлөвшихэд нөлөөлсөн хамгийн гол хүчин зүйл бол өнгөрсөн зуунд эрчимтэй өрнөсөн хэд хэдэн мэдээллийн хувьсгал мөн. Олон нийтийн мэдээллийн харилцаанд болон ОНМХ-ийн үйл ажиллагаа, нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хэлбэр, ур чадвар, үр нөлөө, хүртээмж, шуурхай байдалд эрс өөрчлөлт гарахад нөлөөлсөн үзэгдэл, үйл явцыг мэдээлэл харилцааны хувьсгал гэдэг бөгөөд энэ нь хүмүүсийн хоорондох харилцааны шинэ арга, хэлбэрийг бий болгож, нийгмийн амьдралд шинэ харилцаа төлөвшихөд нөлөөлжээ. Мэдээлэл харилцааны хөгжил нь нийгмийн амьдралд чанарын

шинэ үзэгдлүүдийг төрүүлж, нийгэм дэх мэдээллийн урсгалын хэвшмэл чиглэл, багтаамж, хамрах хүрээг эрс өөрчилсөн.

Ийм мэдээллийн хувьсгал, хөгжил нь жигд бус явагдсан төдийгүй, хувьсгал болгон мэдээлэл харилцааны цоо шинэ арга хэлбэр, урсгал чиглэлийг авч ирсэн түүхтэй.

XX зууны мэдээллийн харилцааны анхны хувьсгал өндөр хөгжилтэй орнуудад XIX зууны эцэст тогтмол хэвлэлийн эрс өөрчлөлтөөр эхэлж, нийгмийн далд давхаргын төлөөлөгчид болох хэт хязгаарлагдмал хүрээний уншигчдад үйлчилж байсан тогтмол хэвлэл 300 жилийн дотор анх удаа олон түмнийг байлдан дагуулж, хоёр зууны зааг дээр мэдээллийн чухал хэрэгсэл

«
*XX зууны мэдээллийн харилцааны
 анхны хувьсгал өндөр хөгжилтэй
 орнуудад XIX зууны эцэст
 тогтмол хэвлэлийн эрс
 өөрчлөлтөөр эхэлж, нийгмийн далд
 давхаргын төлөөлөгчид болох хэт
 хязгаарлагдмал хүрээний
 уншигчдад үйлчилж байсан
 тогтмол хэвлэл 300 жилийн дотор
 анх удаа олон түмнийг байлдан
 дагуулж, хоёр зууны зааг дээр
 мэдээллийн чухал хэрэгсэл болон
 хувирсан юм.*
 »

болон хувирсан юм. Нийгэм, технологи, эдийн засгийн цогц хүчин зүйлийн нөлөөгөөр тогтмол хэвлэлд чанарын шинэ өөрчлөлт гарсан нь сэтгүүл зүйн нийгмийн институт болох ач холбогдол нь эрс өсөн нэмэгдэхэд нөлөөлсөн.

XX зууны эхэнд дуу чимээ, аман мэдээллийн харилцааны боломжийг нэгэн зэрэг өөртөө агуулсан "утасгүй, цахилгаан мэдээ" болох радио харилцаа, холбооны шинэ хэрэгсэл болон

хувирсан нь сэтгүүл зүйн түүхэн дэх цоо шинэ үзэгдэл байсан бөгөөд мэдээлэл харилцааны хоёр дахь хувьсгалын эхлэлийг тавьсан ажээ.

1920-30-аад оны үед радио нэвтрүүлэг газар сайгүй нэвтэрч, сая сая радио сонсогчдыг хамарсан хүлээн авагчдын хамгийн өргөн хүрээнд тогтмол нөлөөлөх шинэ суваг төлөвшсөн юм. Аажим аажмаар тогтмол хэвлэл, радио нэвтрүүлгийн хооронд хамтын ажиллагаа болон өрсөлдөөний харилцаанд үндэслэгдсэн тэгш хэмийн зарчим үйлчлэх болжээ.

Мэдээлэл харилцааны гурав дахь хувьсгал дүрстэй мэдээлэл дамжуулах туршилт алсын зайд тогтмол теле нэвтрүүлэг явуулах шатанд шилжиж, үүний үр дүнд телевиз ОНМХ болж хувирсан явдалтай холбоотой юм. Тавиад оны үед телевиз ОНМХ болж төлөвшсөн нь тогтмол хэвлэл, радио нэвтрүүлгийн хоорондох тэгш хэмийн зарчим зөрчигдөхөд хүргэж, мэдээлэл харилцааны нөхцөл байдлыг дахин өөрчлөхөд нөлөөлжээ. Телевиз бүрэлдэн тогтох сүүлчийн шатанд дэлхийн олон оронд хамгийн олон хүлээн авагчтай, дуу чимээ, эх бичвэр, дүрс бичлэгийн тусламжтайгаар нөлөөлөх чадвар сайтай мэдээллийн хамгийн гол хэрэгсэл болж чадсан юм. Теле нэвтрүүлгийн эрчимтэй хөгжил тогтмол хэвлэл болон радиог тодорхой хэмжээгээр хямралд оруулж, телевизтэй өрсөлдөх шинэ нөхцөл байдалд дасан

зохицох, шинэ арга барилаар ажиллах шаардлага гарчээ.

XX зууны сүүлчийн 25 жилд эхэлсэн мэдээллийн харилцааны дөрөв дэх хувьсгал нь телевизийн мэдээллийн хүрээг үндсээр нь өөрчилснөөрөө онцлогтой юм. Энэ үед сансрын болон кабелийн телевиз эрчимтэй хөгжиж, асар их хэмжээний мэдээллийг цуглуулж, хадгалж, бас дэлхий даяар шуурхай тараах боломжтой компьютерийн сүлжээ бий болсон нь сэтгүүл зүйн хөгжлийг цоо шинэ шатанд гаргажээ. Энэхүү сүлжээний боломж нь эх бичвэрийн, дуу чимээний болон дүрст мэдээллийг тухайн цаг мөчид шуурхай дамжуулж, “уламжлалт” ОНМХ-д тэр бүр байгаагүй мэдээлэл харилцааны шинэ олон талт, идэвхтэй шинжийг нэвтрүүлсэн юм.

Н ааяд оны эхний хагаст “дэлхий дахиныг хамарсан аалзны тор” буюу компьютерийн сүлжээний эрчимтэй хөгжил 90-ээд оны дунд үед сая сая хүн урьд өмнө байгаагүй мэдээллийн асар том бааз руу нэвтрэх боломжтой болжээ. 2000 оны эхэнд дэлхийн 200 сая хүн онлайн мэдээллийн сүлжээнд нэвтэрч байсан бол 2006 онд нэг тэрбум орчим хүн нэвтрэх боломж бүрдэх юм байна. Маш богино хугацаанд мянга мянган сүлжээний “сонин”, “сэтгүүл” дэлхийн аль ч өнцөг буланд байгаагаас үл шалтгаалан сүлжээ ашиглагчдад нээлттэй байх боломж бүрдсэн нь өмнөх үеийн мэдээлэл

харилцааны хувьсгалын явцад ажиглагдаж байгаагүй том амжилт юм.

1995 оноос эхлэн электрон сэтгүүл зүй маш эрчимтэй хөгжиж, зөвхөн дараагийн жил гэхэд АНУ-д сүлжээний 1300 гаруй цахим сонин, сэтгүүл үйл ажиллагаа явуулж байв. Мөн 400 өдөр тутмын сонин, хэдэн зуун сэтгүүл цахим хувилбартай болж, энэ үед өдөр тутам 10 гаруй цахим хэвлэл шинээр гарч байжээ. 2000 оны эхэнд АНУ-ын өдөр тутмын 1500 сонин, 18 мянган сэтгүүл өөрийн Web-site-тай болсон юм. Олон зуун мэдээллийн агентлаг, телекомпани, радиостанци Web-зангилаатай болж, радио нэвтрүүлэг, телевизийн хөтөлбөрийг сүлжээгээр дамжуулах явдал бодит зүйл болов.

Компьютерийн сүлжээ эрчимтэй хөгжсөн нь XX зууны мэдээллийн хэрэгслээс зарчмын эрс ялгаатай тоон технологи бүхий шинэ хэрэгсэл үйлчилдэг даяарчлалын үеийн мэдээллийн орон зайг бүрдүүлж байна. Өнөөдөр Интернетэд өргөн хүрээний мэдээллийн баазтай, дуу чимээтэй, эргэх холбоо бүхий мультимедиагийн бүх шинэ чанарыг өөртөө агуулсан "цахим сонин", "цахим сэтгүүлүүд" бий болжээ. Судлаачид ирээдүйд компьютерийн мэдээлэл харилцааны сүлжээний тусламжтайгаар тогтмол хэвлэл, радио, телевиз нэгдэн нийлэх үйл явц хүчтэй явагдах болно гэсэн таамаглал дэвшүүлж байна.

Орчин үед ОНМХ-д хандах уламжлалт хандлага өөрчлөгдөж, уламжлалт болон уламжлалт бус мэдээллийн

хэрэгслүүдэд хуваагдаж, шинээр үүссэн мэдээллийн хэрэгслүүд дэлхийн аль ч орны хувьд чухал хүчин зүйл болж байна. Өөрөөр хэлбэл, мэдээлэл харилцааны шинэ дүр төрх, шинэ орчныг бий болгосон бөгөөд энэхүү бодит хүчин зүйл ОНМХ-д өөрөөр хандахад хүргэж байна. Мэдээлэл харилцааны ийм нөхцөлд уламжлалт, ОНМХ-үүд өөрийнхөө байр суурийг хадгалан үлдэж, ач холбогдлоо алдахгүй байхын төлөө тэмцэж, үйл ажиллагааны үүрэг зорилго, чиглэл, арга хэлбэр, бүтэц зохион байгуулалтыг ихээхэн өөрчлөн шинэчлэж байна. Гурав дахь цахим мэдээллийн хэрэгсэл Интернет нийгмийн бодит хэрэгцээ болж, иргэдийн ажил төрөл, ахуй амьдралд идэвхтэй нэвтрэч, мэдээлэл харилцааны технологийн хөгжил дэвшил бодит үзэгдэл болсноор мэдээллийн нийгмийн эх суурь тавигдсан билээ. Одоогоос 10 жилийн өмнө "Датаком" компани Интернетийн сүлжээг Монголд оруулж ирсэнээр манай орныг мэдээллийн глобаль орчинд нэвтрэх боломжийг нээсэн бөгөөд улс орны ирээдүйн хөгжлийн хамгийн чухал стратеги зорилтуудын нэг нь мэдээллийн нийгмийг байгуулах, мэдээллийн шинэ хэрэгслүүдийг эрчимтэй хөгжүүлэх явдал болсон юм. Өнөөдөр төр, засгийн аль ч удирдагч мэдээллийн нийгэм ба мэдээллийн технологийг хөгжүүлэх талаар олонтаа ярьдаг болсон нь чухам үүнтэй холбоотой юм.

Европын Холбооны дэргэд ажилладаг мэдээллийн нийгмийн асуудал

хариуцсан тусгай комисс эдийн засгийн шинэ хувьсгалын үзэл баримтлалыг боловсруулснаар "Европ зөвхөн шинэ цахим эдийн засгийн орон зайн нөхцлийг бүрдүүлсэн тохиолдолд л эрчимтэй хөгжих болно"⁴ гэсэн дүгнэлтэд хүрчээ. Энэ бол мэдээллийн нийгмийн ач холбогдол хэр зэрэг чухал байгааг хүлээн зөвшөөрсөний илрэл юм.

Мэдээллийн нийгмийн хөгжлийн чухал үндэс суурь болох Интернет манай орон дэлхий дахины мэдээллийн орон зайд нэвтрэх, ирээдүйд орчин үеийн элит улс орнуудын хүрээнд багтахад нөлөөлөх шийдвэрлэх хүчин зүйл бөгөөд орчин үед мэдээллийн технологид онцгой анхаарч, мэдээллийн нийгмийг байгуулахгүйгээр хөгжлийн талаар мөрөөдөхийн ч хэрэггүй гэдэг нь ойлгомжтой. Интернет-

тэд нэвтрэх, түүнийг хэрэглэх явдал нь улс орнуудыг мэдээллийн хувьд баян, мэдээллийн хувьд ядуу оронд хуваадаг. Харамсалтай нь манай орон мэдээллийн хувьд ядуу орны тоонд багтдаг. Иргэдийн 7 хувь нь Интернет хэрэглэж, хөдөө орон нутагт дөнгөж эхлэл төдий байгаагаар үүнийг тайлбарлаж болно.

Өнөөдөр глобаль телесүлжээнүүд хил хязгааргүй өргөн хүрээнд үйлчилж,

нэгэн зэрэг янз бүрийн виртуаль нэгдлүүдийг үүсгэн байгуулах өргөн боломж нээгдэж байна. Энэ бүхэн нь виртуаль хэмээн нэрлэгддэг цоо шинэ нөхцөл байдлыг бий болгож, эдийн засгийн болон мэдээллийн бодит орчинд хүчтэй нөлөө үзүүлж байна.

Орчин үед дэлхий дахинд мэдээлэл солилцох гурван чухал үйл явц ихээхэн эрчимтэй явагдаж байна. Энэ бол, нэгдүгээрт, даяарчлал буюу дэлхий

дахинд мэдээллийг маш шуурхай солилцох үйл явц. Хоёрдугаарт, орон нутгийн жижиг бүтцүүдийг хөгжүүлэх. Өөрөөр хэлбэл, орчин үеийн мэдээлэл харилцааны сүлжээ нь бага бүлэг, түүний дотор бага үндэстэн, ястнууд өөрсдийн төлөөлөгчдийг хил хязгаар, газар зүйн орчныг үл харгалзан нэгтгэх замаар вир-

«

Мэдээллийн нийгмийн хөгжлийн чухал үндэс суурь болох Интернет манай орон дэлхий дахины мэдээллийн орон зайд нэвтрэх, ирээдүйд орчин үеийн элит улс орнуудын хүрээнд багтахад нөлөөлөх шийдвэрлэх хүчин зүйл бөгөөд орчин үед мэдээллийн технологид онцгой анхаарч, мэдээллийн нийгмийг байгуулахгүйгээр хөгжлийн талаар мөрөөдөхийн ч хэрэггүй гэдэг нь ойлгомжтой.

»

туаль орон зайд оролцох боломжийг өгч байна. Энэ нь мэдээллийн жижиг сүлжээ, бүлгүүдийг бий болгоход хүчтэй нөлөө үзүүлдэг юм. Гуравдугаарт, олон нийтийн хэрэгслүүдийг технологийн детерминизм руу хөтөлсөн технологизм буюу утсан холбоо, технологийг гүйцэж түрүүлсэн үүрэн телефоны хөгжил Интернетэд нэвтрэх шинэ хандлага, боломжийг нээж өгч байна.

Манай орны хувьд Интернет дэлхий дахины мэдээллийн болон эдийн засгийн орон зайтай холбох чухал суваг болж байгаа бөгөөд энэ нь орчин үед эдийн засгийг мэдээллийн дэд бүтэцгүйгээр, даяарчлалын системийн гадуур хөгжүүлэх боломж үндсэндээ үгүй болсонтой шууд холбоотой юм. Энэ талаар төр, засгийн зүгээс бие даасан Мэдээлэл технологийн газрыг байгуулж "цахим хөтөлбөр"-ийг баталж, өрх бүрийг компьютертэй болгох зэрэг нааштай алхмыг хийж эхэлсэн боловч постсоциалист зарим оронтой харьцуулахад ихээхэн хоцорч байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Интернетэд цөөхөн хэдэн цахим хэвлэл монгол хэл дээр гарч, өдөр тутмын томоохон сонинууд цахим хувилбартай болж, ТВ-5, UBS, 25-р суваг телевиз, хэд хэдэн FM радиостанциуд интернетээр нэвтрүүлгээ цацах болсныг эс тооцвол тоймтой юм хэлэх боломжгүй юм.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудынх шиг Интернет болон мэдээллийн технологийн бусад боломжийг ашиглан дэлхий даяар тардаг нэг ч глобаль сонин алга байна. Хэдийгээр ХМХ тооны хувьд хангалттай мэт боловч бараг бүгд нийслэлд гардаг учир орон нутгийн иргэд мэдээлэл хүлээж авах боломж хязгаарлагдмал, мэдээллийн хүртээмжтэй, шуурхай байдал ч хангалтгүй юм. Интернет хэрэглэгчдийн тоо ч цөөхөн, орон нутагт дөнгөж нэвтэрч эхэлсэн дээр нь иргэдийн гадаад хэлний мэдлэг дутмаг, компьютерийн үнэ өртөг өндөр

зэрэг багагүй бэрхшээл байгааг хэлэх хэрэгтэй.

Ийм бэрхшээл цөөнгүй боловч өнөөдөр Интернет манай орны мэдээллийн зах зээлд чухал үүрэг гүйцэтгэх болж, иргэдийн мэдээлэл олж авах, янз бүрийн баримт бичигтэй танилцах, мэдлэгийн хүрээг өргөтгөхөд үнэлж баршгүй нөлөө үзүүлэх болжээ. Энэ бол мэдээллийн нийгэм байгуулах замд хийж буй томоохон алхам гэж хэлж болно. Учир нь мэдээллийн нийгэм эдийн засаг, соёл боловсролыг хөгжүүлэхэд мэдээллийн орон зайг өргөн ашиглахыг шаарддаг. Чухам энэ хүчин зүйлээс манай орны ирээдүйн хөгжил дэвшил, төлөв байдал шалтгаалах болно.

Мэдээллийн нийгэм өндөр соёлыг, бас мэдээллийн шинэ технологид идэвхтэй нэвтрэхийг шаарддагаараа онцлогтой юм. Учир нь интернет мэдээллийн, эдийн засгийн, санхүүгийн, худалдаа арилжааны, нийтийн шинэ виртуаль орон зай төдийгүй нэг талаар хувь хүн, нөгөө талаар олон нийтийн мэдээлэлд нэвтрэх, мэдээлэл олж авах шинэ хэрэгсэл мөн. Мэдээллийн нийгэм болон олон нийтийн мэдээллийн шинэ хэрэгслүүдийн харилцан нөлөөллийн тухай ярихдаа юуны өмнө дараах гурван чухал хүчин зүйлд онцгой анхаарах шаардлагатай юм. Энэ нь:

1. Мэдээллийг орчин үеийн мэдээлэл харилцаны шинэ технологи болон Интернетийн тусламжтайгаар дамжуулах боломж,

2. Интернетчлах үйл явцын өнөөгийн шинэ нөхцөлд уламжлалт ОНМХ-үүдийн үйлчлэх хүрээг өргөтгөх,

3. Шинэ масс-медиа буюу олон нийтийн мэдээллийн шинэ хэрэгслүүдийг бий болгох зэрэг болно.

Өнөөдөр харилцааны болон мэдээлэл дамжуулах технологи маш эрчимтэй өөрчлөгдөж байна. Интернет олон нийтийн харилцааны цоо шинэ боломж, орон зайг бий болгосон нь ОНМХ-ийн хөгжилд хүчтэй нөлөө үзүүлж байна. Манай орны хэвлэл мэдээллийн систем үндсээр нь өөрчлөгдөж чадаагүй ч бүтэц зохион байгуулалт, нийтлэл нэвтрүүлгийн агуулга, хэлбэр, бичлэгийн арга барилын хувьд ихээхэн ахиц өөрчлөлт гарсан нь тодорхой юм. Ямар ч байсан мэдээлэл харилцааны ертөнц бүхэлдээ хөдөлгөөнд орж, өөрчлөлт шинэчлэлтийн замд эргэлт буцалтгүй орсон нь ил байна.

Орчин үеийн мэдээлэл харилцааны шинэ технологийн хамгийн чухал элемент нь дижитализаци буюу тоон технологи бөгөөд ОНМХ-ийн мэдээллийн агуулгыг тооны хэлбэрт шилжүүлэх үйл явц юм. Үүний үр дүнд бүх ОНМХ-ийн нийтлэг шинж, нийтлэг нэгж нь тоон хэмжүүрийг агуулсан эх бичвэр болж байна. Товчоор хэлбэл ОНМХ-үүд нэгдэн нийлэх үйл явц эрчимтэй явагдаж эхэллээ. Мэдээллийн шинэ орчин мэдээллийг дамжуулах хэлний хүрээнд ч хүчтэй нөлөөлөх болж, хэлний шугаман бүтцийн хамт гипер эх бичвэрийн бүтэц зэрэгцэн орших болов.

Уламжлалт ОНМХ-үүд өөрийнхөө мэдээллийг үндэсний хэмжээнд болон дэлхий дахинд түгээхэд Интернетийг өргөн ашиглаж эхэлсэн. Өнөөдөр дэлхийн өнцөг буланд амьдарч байгаа монгол угсаатнууд цахим хэвлэл болон томоохон сонин хэвлэлийн Интернет хувилбараар дамжуулан Монголын тухай мэдээллийг шуурхай хүлээж авч байна. Зарим радио станци болон телевиз Интернетийг ашиглан нэвтрүүлгээ эх орны өнцөг булан төдийгүй дэлхий дахинд цацах болсон нь монголын сэтгүүл зүйн хөгжил дэх цоо шинэ үзэгдэл гэж хэлж болно.

Манай тогтмол хэвлэл радио, телевизтэй харьцуулахад Интернетийн боломжийг илүү өргөн ашиглаж байна. Энэ нь эх бичвэр аль ч мэдээллийн хэрэгслийн хувьд нийтлэг зүйл болдогтой холбоотой юм. Интернетээс шаардлагатай эх бичвэрийг хэвлэж авах бүрэн боломжтойгоос гадна зарим цахим сонин хэвлэл өөрийнхөө хэвлэмэл хувилбарыг гаргаж эхэлсэн нь бас нэг шинэлэг зүйл мөн. Бүх ХМХ бие даасан, хараат бус эх бичвэрийг өргөн ашигладаг. Ингэхдээ сонин, сэтгүүлүүд радио, телевизтэй харьцуулахад ихээхэн давуу талтай гэдэг нь тодорхой юм. Тогтмол хэвлэлд нийтлэгдсэн материалуудыг өндөр төвшинд боловсруулж, сайн хянан найруулдаг учраас уншигч гүнзгий дүн шинжилгээ хийсэн, үнэлэлт дүгнэлт сайтай мэдээлэл хүлээн авах боломжтой.

Мэдээллийн глобаль сүлжээ үүссэнээр бий болсон ХМХ-ийн цоо шинэ

төрөл бол цахим сонинууд бөгөөд байнга шинэчлэгдэж байдаг, өнгө үзэмж сайтай байгаагийн хамт тавигдсан мэдээ материал нь төгсгөлгүй үргэлжилж байдаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, үйл явдал дууссан үед л тухайн материал дуусах болно. Энэ утгаар нь авч үзвэл Интернетэд байрлагдсан цахим сонины сэтгүүлчид байнга ажиллаж байдаг, тэдний материалын сүүлчийн өгүүлбэрийг үргэлж баяжуулж, нэмж бичих боломжтой гэсэн үг.

Цахим сонины өөр нэг өвөрмөц онцлог нь гипер эх бичвэрүүдийн боолтоос бүрддэгт оршдог. Энэ нь янз бүрийн материалуудыг амархан эрж хайх, шаардлагатай мэдээллийг шуурхай олж авахад тусалдаг. Цахим сонинууд мэдээллийн багтаамж сайтай, сонирхолтой, утга төгөлдөр, мөн шуурхай байгаагаараа ихээхэн давуу талтай юм. Цахим хэвлэл шуурхай шинжээрээ зөвхөн тогтмол хэвлэл төдийгүй зарим телевизээс ч түрүүлж мэдээлэл өгч чаддаг. Орчин үед хүлээн авагчдад эх бичвэрийн болон дуу чимээ, дүрс бүхий бүх төрлийн мэдээллийг нэгэн зэрэг өгч чаддаг цахим мэдээллийн агентлаг бий болсон нь хэвлэл мэдээллийн шинэ хэрэгслийн гол онцлог, давуу тал юм. Уламжлалт мэдээллийн хэрэгслүүдтэй зэрэгцэн оршиж буй мэдээллийн ийм шинэ хэрэгслүүд хүлээн авагчдад мэдээллийг шуурхай хүргэх, гэр орон, ажлын байранд амар хялбар мэдээлэл хүлээж авах боломжоороо тэднийг аль хэдийд давж гарсан. Гэхдээ

тогтмол хэвлэл агуулж буй мэдээллийн шинжлэлт чанар, өгч байгаа үнэлэлт дүгнэлтээрээ давуу талтай гэдэг нь ойлгомжтой. Нөгөө талаар ихэнх материалыг бусад ХМХ-ээс шууд авч нийтэлсэн идэвхгүй мэдээлэл голлодог сул талтай юм.

Аливаа шинэ мэдээллийн хэрэгсэл үүсэхэд өмнөх мэдээллийн хэрэгсэл устаж үгүй болдог, байр сууриа алддаг талаар ярьж эхэлдэг. Радио, телевиз үүсэхэд ном, сонины сүйрэлийн тухай ярьж, хүмүүс сонин хэвлэл уншихаа болих тухай ярьдаг байсан ч өнөөдөр хүртэл тийм юм болоогүй. Харин Интернет хүчтэй нэвтэрснээр сонин, сэтгүүлийн тоо, чанарт хүчтэй нөлөө үзүүлэх болж, сонин хэвлэл мэдээллийн өрсөлдөөнд хуучин байр сууриа хадгалан үлдэхийн тулд чадах бүхнээ хийж байгаа боловч тооны хувьд хорогдсоор байна. Дэлхийн сонинуудын холбооны мэдээллээс үзвэл сонин уншигчдын тоо жил тутам 600 мянган хүнээр цөөрч, сонины хэвлэгдэх хувь нь 15 хувиар багасч байгаа ажээ. Ялангуяа 18-24 насныхан сонин унших явдал эрс буурчээ⁵. Сүүлийн жилүүдэд ийм хандлага манай мэдээллийн зах зээлд ч ажиглагдах болсныг төвөггүй мэдэрч болно.

Ер нь мэдээллийн нийгэмд шилжих үйл явц тухайн орны шинжлэх ухаан техникийн дэвшил, эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлөөс ихээхэн шалтгаалдаг нь тодорхой. Манай орны нийгэм-эдийн засгийн хөгжлийн өнөөгийн

төвшин, нөхцөл байдлаас үзэхэд мэдээллийн нийгмийн тухай ярих нь арай эрт боловч өнөөдөр тэр нийгмийн зарим нэг шинж тэмдэг тодорхой илэрч байгааг зөвшөөрөх хэрэгтэй.

Компьютертэй айл өрхийн тоо жилээс жилд нэмэгдэж, "Цахим хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхэлснээр Интернетийн хэрэглээ өргөжиж байна. Хот суурин газруудад оршин суугчид Интернетийн тусламжтайгаар дотоодын болон дэлхий дахины мэдээллийн орон зайд нэвтэрч, хүссэн мэдээллийг олж авах болсон. Мөн сүүлийн үед цахим засаглалын талаар ярих болж, энэ чиглэлийн тодорхой хөтөлбөр боловсруулж эхэлжээ. Дээр нь үүрэн телефоны хэрэглээ ихээхэн өргөжиж, мэдээлэл солилцох, иргэдийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, зардал

хэмнэх чухал хэрэгсэл болсон зэрэг нь бид ямар нэг хэмжээгээр мэдээллийн нийгэмд хөл тавьсаны шинж юм. Гэхдээ манай оронд мэдээллийн нийгмийг хөгжүүлэх үйл явцад дараах гурван хүчин зүйл сөрөг нөлөө үзүүлж байна. Нэгдүгээрт, дэд бүтэц, түүний дотор харилцаа холбооны хөгжил сул, үнэ өртөг өндөр байна. Үүрэн телефоны хэрэглээ өсч, энэ салбарыг либералчилсан явдал үнэ өртгийг тодорхой

хэмжээгээр бууруулахад нөлөөлсөн. Цаашид харилцаа холбооны бүх салбарыг либералчлах замаар өрсөлдөөн бий болгох нь энэ салбарын хөгжлийг шинэ шатанд гаргахад нөлөөлөх болно. Өнөөдөр дэлхий даяар утасны харилцаа холбоог либералчлах үйл явц эрчимтэй явагдаж байгааг анхаарч, зоригтой алхам хийх шаардлага тулгарч байна.

Хоёрдугаарт, компьютерийн хүрэлцээ, хангамж муу байна. Өнөөдөр дэлхий дахинд компьютерийн тооны дундаж хэмжээ 15,5 хувьтай байхад манай орон ердөө 2 хувьтай бөгөөд Африк тивийн дундаж үзүүлэлтээс ч бага юм. Улсын хэмжээнд 50000 гаруй компьютер байгаагийн 10 орчим хувийг гэрийн нөхцөлд ашигладаг байна. Компьютерийн үнэ өртөг нь өндөр, иргэдийн амьжиргааны төвшин доо-

«

Цаашид харилцаа холбооны бүх салбарыг либералчлах замаар өрсөлдөөн бий болгох нь энэ салбарын хөгжлийг шинэ шатанд гаргахад нөлөөлөх болно. Өнөөдөр дэлхий даяар утасны харилцаа холбоог либералчлах үйл явц эрчимтэй явагдаж байгааг анхаарч, зоригтой алхам хийх шаардлага тулгарч байна.

»

гуур байгаа нь мэдээллийн нийгэм байгуулахад учирч буй гол бэрхшээл юм. "Цахим хөтөлбөр"-ийн хүрээнд компьютерийг гаалийн татвараас чөлөөлж, лизингээр өгч эхэлсэн нь нааштай алхам боловч олон хүчин зүйлээс шалтгаалж ихээхэн удаашралтай байна. Хамгийн гол нь иргэд ядуу, компьютер худалдаж авах мөнгөгүй байхад энэ асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх боломжгүй гэдэг нь ойлгомжтой.

Гурав дахь хүчин зүйл бол Интернетийн хэрэглээ бөгөөд манай оронд 180 000 орчим хэрэглэгчтэй гэсэн тоо байдаг боловч үнэн хэрэг дээрээ 60 мянга хүрэхгүй хүн л байнга хэрэглэдэг байна. Манайх шиг ядуу орны хувьд шуудан холбоо, номын сан болон бусад олон нийтийн газарт Интернет ашиглах боломжийг сайжруулж, Интернет-кафенй тоог (одоо 120 гаруй бий) нэмэгдүүлэх нь энэ асуудлыг нааштай шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх болно.

Бид мэдээллийн нийгмийн тухай ярихдаа түүний хүмүүсийн аж төрөх ёс, ахуй амьдралд үзүүлэх нөлөөг дутуу үнэлдэг нь ажиглагддаг. Өнөөдөр мэдээллийн нийгэм удирдлагын болон үйлдвэрлэлийн цоо шинэ харилцааг бий болгож, үйлдвэр, яам болон бусад байгууллагууд өмнөх үеийн учир утгыг алдаж эхэлсэн. Теле ажил, Интернет-холбоо бие хүний нөөц боломж, чадавхийг ашиглах замаар маш шуурхай, үр дүнтэй ажиллах боломжийг олгож байна.

Цаг хугацаа, орон зай эрс өөр шинжийг агуулах болсон өнөөгийн нөхцөлд телеажил төвлөрийг сааруулах, хүмүүсийн хөдөлмөрийг хөнгөвчлөх, цаг хугацаа хэмнэх, түргэн шуурхай үйлчлэх цоо шинэ боломжийг нээж өгч байна. Энэ бүхнийг мэдээллийн технологийн тусламжтайгаар шийдэх нь тодорхой. Өнөөдөр “аливаа орны хил хязгаар хилчид зогсож байгаа зурвас биш, харин мэдээллийн саад бэрхшээл байгаа тэр газар мөн” гэж ярьдаг болсон. Орчин үед манай орны хил хязгаар

Интернет дэх манай сектор болох Монголнетэд байрладаг гэж хэлж болно. Монголнетэд нэвтрэнэ гэдэг бол Монгол улсаар аялж байна гэсэн үг. Тиймээс бидний мэдээллийн нийгэм байгуулах замд хийх том алхам бол юуны өмнө Монголнетийг улам боловсронгуй болгох, баяжуулах, хөгжүүлэх явдал юм. Мэдээллийн нийгэм хүн төрөлхтөнд шинэ зүйлийг сэтгэх, бодох, санаачлага гаргах, авьяас чадвараа хөгжүүлэх, түүнийг практикт шуурхай нэвтрүүлэх шинэ боломжийг өгч байна. Энэ бол бүх төрлийн төвлөрлийг сааруулах, хөндлөн болон сүлжээний бүтцийг хөгжүүлэхийг шаардаж буй хэрэг юм. Бид социалист систем яагаад задарч унасан талаар янз бүрийн таамаглал дэвшүүлж, дүгнэлт хийдэг мөртлөө төвлөрсөн босоо удирдлагатай тогтолцоогоор шинэ эрин, шинэ технологид орох боломжгүй байсан талаар бодож байгаагүй.

Мэдээллийн нийгмийг амжилттай хөгжүүлэхэд нөлөөлөх хамгийн гол хүчин зүйлүүдийн нэг бол хөндлөн болон сүлжээний бүтцийг өргөжүүлэх, эрчимтэй хөгжүүлэх явдал юм. Энэ нь иргэн бүрийн шинэ санал, санаачлагыг түгээн дэлгэрүүлэх, олны хүртээл болгох шинэ боломжийг нээх болно. Жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх гол эх үүсвэр, нөөц боломж төдийгүй аливаа шинэ санааг практикт шуурхай нэвтрүүлэх, амьдралд хэрэгжүүлэх оновчтой, найдвартай арга юм.

Манай орон Интернетэд удаан, бас жигд бус нэвтэрч байгаа нь түүнийг

ОНМ-ийн элит хэрэгсэл болгоход хүргэж, хот суурин газруудад ХМХ-ийн харьцангуй ардчилсан хэлбэр, хөдөө орон нутагт тэр баргийн хүнд хүртээлтэй бус мэдээлэл харилцааны элит хэлбэр болсон нь ажиглагддаг.

Өнөөдөр Интернет энгийн иргэд, сэхээтний элит давхарга, бүх төрлийн байгууллага, ХМХ-үүдэд үйлчилж, тэд хүссэн мэдээллийг олж авч байгаагийн хамт сүүлийн үед сонгуулийн сурталчилгаа, мөн реклам сурталчилгааны хэрэгсэл, өөрийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлдэг нэг ёсны "хувийн мэдээллийн хэрэгсэл" болгон ашиглаж байна. Интернет хэрэглэгчдийн ихэнх нь электрон захиа бичих, янз бүрийн зугацуулах зорилго бүхий сайтуудад орох зорилгоор ашигладаг бол харьцангуй бага хэсэг нь мэдээлэл олж авах зорилгоор ханддаг байна. Энэ бүхнийг дүгнэж хэлбэл:

Интернет маш удаан, жигд бус нэвтэрч байгаа бөгөөд нийт хүн амын дөнгөж 7% буюу 180 000 хүн орчим ямар нэг байдлаар интернет хэрэглэгч байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт мөн. Тэгвэл энэ үзүүлэлт постсоциалист орон болох Словенид 40, Эстони 35, Польшид 25, Унгар 25 хувьтай байна.

Хот суурин газруудад Интернет мэдээллийн орон зайд чөлөөтэй нэвтрэх хэрэгсэл болсон бол хөдөө орон нутагт мэдээллийн элит хэрэгсэл болж, зөвхөн электрон шуудангийн үйлчилгээгээр хязгаарлагдаж байна.

Судлаачид, профессорууд, албаны хүмүүс, "шинэ" монголчууд зэрэг "цахим мэдээллийн баян" хүрээ, мөн өндөр настангууд, малчин тариаланчид, орон нутгийн сэхээтнүүд зэрэг "цахим мэдээллийн ядуу хүрээ бий" болжээ.

Залуучууд болон ахмад үеийнхний хооронд, мөн нийгмийн янз бүрийн давхаргад хамрагдах залуучуудын хооронд интернет хэрэглэгчдийн тооны ялгаа асар их байгаа нь зарим хэсэг нь гадаад ертөнцийн соёлтой танилцах өргөн боломж олгож байгаа бол зарим хэсгийн хувьд зөвхөн өөрийн санал бодлыг илэрхийлэх "хувийн мэдээллийн хэрэгсэл" төдий байна. Удирдах хүмүүс буюу элит давхаргынхан бүгд интернеттэй холбогдсон компьютертэй боловч түүнийг ашиглахыг зөвхөн туслахууд, нарийн бичгийн дарга нарт даалгасан, бусад хүмүүстэй, гадаад ертөнцтэй тэдний тусламжтайгаар харьцдаг мэдээлэл харилцааны хоёр төвшинт тогтолцоо бий болжээ.

Энэ бүхнээс үзэхэд Интернет хэрэглэгчдийн хоорондох ийм тооны ялгаа нь мэдээллийн нийгэм байгуулах явц дахь хамгийн тод илэрч буй зөрчил, саад бэрхшээл бөгөөд үүнийг иргэдийн идэвхтэй оролцоо, хичээл зүтгэл, санаачлагыг эрс дээшлүүлэх замаар арилгах нь улс орны нөөц боломж, чадавхыг бүрэн дүүрэн ашиглах, өөрчлөн шинэчлэх, сэргээх найдвартай баталгаа, ардчиллын болон зах зээлийн эдийн засгийн салшгүй хэсэг болно. Хэдийгээр ийм дутагдал байгаа боловч

интернетийн хөгжил, хөдөлгөөний өнөөгийн дүр төрх нь ардчилал, зах зээлийн эдийн засгийн хөгжлийн замд яваа манай орныг өөрчлөн шинэчлэх гол хүчин зүйл болох мэдээлэлжүүлэх, интернетчлах үйл явцыг эрчимжүүлэх итгэл найдвар төрүүлж байна.

Ишлэл

¹ З у л ь к а ф и л ь М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ., 70 дахь тал.

² З и н о в ь е в А. А. 1997. Глобальный человек. М., с. 78.

³ Цит. по: Политическая энциклопедия. 1999-2000. В 2-х тт. (Под ред. Т.Ю. Семигина). М., с. 188.

⁴ Ф е д о т о в а Л. Н. 1996. Массовая информация: стратегия производства и тактика потребления. М., с. 132.

⁵ <http://www.wan.press.org> (WAN – World Association of Newspapers).

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. А б д е е в Р. Ф. 1994. Философия информационной цивилизации. М.

2. Б е с п а л о в А. Г. и др. 2004. История мировой журналистики. Ростов-на-Дону.

3. З и н о в ь е в А. А. 1997. Глобальный человек. М.

4. З у л ь к а ф и л ь М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

5. Политическая энциклопедия. 1999-2000. В 2-х тт. (Под ред. Т.Ю. Семигина). М.

6. Ф е д о т о в а Л. Н. 1996. Массовая информация: стратегия производства и тактика потребления. М.

7. W e b s t e r F. 1998. Theories of the Information Society. London and N.-Y.

8. <http://www.eim.de> (EIM – European Institute for the Media).

9. <http://www.wan.press.org> (WAN – World Association of Newspapers).

Резюме

Статья посвящена проблемам развитию информационного общества и роли СМИ в этом обществе. Автор на основе реальных фактов и современных концепций ведущих учёных мира показывает особенности развития информационного общества в Монголии и определяет трудности и препятствия, встречающие в этом процессе. Анализируя современные состояния монгольского общества и средств массовой информации, автор предлагает оптимальные варианты развития новых средств массовой информации и новой технологии Mass Media, также определяет положительно влияющие факторы на развитие информационного общества.